

Батлав. БОУАӨЯ-ны, Хүрээлэн буй орчны,  
бодлогын хэрэгжилтийн дарга

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг  
хүлээсэн:  
“РЭДВУЛКАН” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

\_\_\_\_\_ Г.Энхмөнх

\_\_\_\_\_ Л.Мөнхсайхан

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ, АР НАЙМГАНЫ ДЭЭД  
ХЭСЭГТ ОРШИХ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-015478, MV-015480 /

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5292638 /

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБНУГ-ын шинжээч..... / /

Боловсруулсан:

“РЭДВУЛКАН” ХХК-ийн байгаль

орчны мэргэжилтэн ...../ Э.Намсрай /

2024 он

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтний хувийн дугаар	
Дүгнэлт	
Шийдвэрийн төсөл	
Ололт, амжилттай тал	
Дутагдалтай сул тал	
Шаардлага	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ ..... он ..... сар ..... өдөр /

Нэг. Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамаарахгүй хэсгийг “*хамааралгүй*” гэж бөглөх.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Редвулкан ” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011187051
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Ашигт малтмалын ашиглалт,
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Монгол Улс Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, 143.5-гоо
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Л.Мөнхсайхан 99071229 bayarbaatar.byamba@gmail.com
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Э.Намсрай, 90100632, Namsrai927@gmail.com
1.2	1. Төслийн нэр	“Ар наймганы дээд хэсэг нэртэй” алтны шороон орд
	2. Төслийн харъяаллын байршил	Төв аймаг Заамар сум
	3. Төслийн ангилал	Уул уурхайн төсөл
	а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр, гэх мэт	Алт
	б. ил уурхай, далд уурхай, шороон орд	Ил уурхай
	в. баяжуулах үйлдвэр	Усаар угаан гравитацийн аргаар баяжуулдаг
	4. Төсөл эхэлсэн огноо	2024

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Намсрай*...../

огноо

/ *2024* он *10* сар *28* өдөр /

5. Төсөл хэрэгжих хугацаа	2 жил
6. Уурхайн хаалт эхлэх огноо	2028
7. Хаалтын дараах зориулалт	Хадлан бэлчээр
8. ТЭЗҮ баталсан огноо	2024
9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	-
10. Ажилчдын тоо	65
11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	-
12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	-
<ul style="list-style-type: none"> <li>• замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл</li> </ul>	-
<ul style="list-style-type: none"> <li>• шатахуун түгээгүүрийн тоо</li> </ul>	5 тн түлш түгээгүүрийн машинтай
<ul style="list-style-type: none"> <li>• шатахууны агуулахын агууламжийн хэмжээ</li> </ul>	50 тн багтаамжтай 2 агуулах,
<ul style="list-style-type: none"> <li>• тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт</li> </ul>	Тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэхгүй

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Мамсрай*...../

огноо

/ 2024 он ...10... сар 28... өдөр /



Хоёр. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгогддог тусгай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны товч мэдээлэл

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ <ul style="list-style-type: none"> <li>• Дугаар</li> <li>• Хүчинтэй хугацаа</li> <li>• Талбай</li> </ul>	Алт MV- 015478, MV-015480 30 жил 71 га 15 га
2.1	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	
	3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	-
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2024 “Эко хайрхан консалтинг” ххк

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Намгасай*...../

огноо

/ *2024* он ...*10* сар *25* өдөр /

6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		2024-БОУАӨЯ	
7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо		2024	
8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо		Хавсаргав	
9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах		Хавсаргав	
10. Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт онд гүйцэтгэх	-
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт онд гүйцэтгэх	-
			-
			-
11. ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах		Хавсргав	
12.Тухайн жилд баримтлах стандартын дугаар <input checked="" type="checkbox"/> Үндэсний <input type="checkbox"/> Олон улсын		Хавсаргав	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Аамсрай*...../

огноо

/ 2024 он ...10... сар ...28... өдөр /

Гурав. Химийн бодисын эрсдэл, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заасны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн бодисын хор, аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хавсралтаар оруулж, доорх хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах (хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай)
- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Тусгай зөвшөөрөл шаардагдах химийн бодис ашиглахгүй
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө урьдчилан сэргийлэх арга хэмжээ - эрсдэлийн үед авах арга хэмжээ - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	Хамааралгүй
3.2	1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Хамааралгүй
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/  • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ Аюултай хог хаягдал	
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	2500.0

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Чалсрай*...../

огноо

/2024 он ...10... сар .28. өдөр /

**Дөрөв. байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв**

- Доорх хүснэгтийн 4.1.2 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	12 726 000
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв / технологийн зөв шийдэл /	-
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	5 100 000
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	-
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	-
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	300 000
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1 130 000
	8. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-
	9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1 796 000

Тав. Мета мэдээлэл

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Э.Мисраи*...../

огноо

/ 2024 он .10 сар .26 өдөр /

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг байгаль орчны мэдээллийн санд оруулна.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	
	Хог хаягдлын цэгийн байршил	
	Аюултай хог хаягдлын агуулахын байршил	
	Хаягдлын далан	
	Химийн бодисын агуулахын байршил	
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	
	Хяналтын цэгийн байршил	
	Тухайн жилд хуулах хөрс	
	Гадаад, дотоод овоолго	
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	
	Гүний худгийн байршил	
	Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ ..... он ..... сар ..... өдөр /

Зургаа. Тухайн жилийн арга хэмжээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээний хяналтын хуудас

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх баганд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй”, “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
<p>6. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулах</li> <li>• Эвдэх</li> <li>• Доройтуулах</li> </ul>					
<p>6. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулах</li> <li>• Нөөцийг бууруулах</li> </ul>					

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ ..... он ..... сар ..... өдөр /

<p>6. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл амьдрах орчинг хуваах</p> <ul style="list-style-type: none"> <li>• амьдрах орчинг доройтуулах</li> <li>• амьдрах орчинг хомсдуулах</li> <li>• нөөцийг бууруулах</li> </ul>					
<p>6. Агаарт үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулах</li> <li>• тоос</li> </ul>					
<p>6. Түүх соёлын дурсгалт эд зүйлс</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хамгаалах</li> <li>• Нүүлгэн шилжүүлэх</li> </ul>	хамааралгүй	хамааралгүй	хамааралгүй	хамааралгүй	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ ..... он ..... сар ..... өдөр /

Долоо. Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтнүүд “хангалттай” “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх		В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
1. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	13	Тийм	Тийм		
2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13	Тийм	Тийм		
3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ <ul style="list-style-type: none"> <li>• техникийн/ га эзэлхүүн</li> <li>• биологийн /га</li> </ul>	-	Тийм	Тийм		
4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	үгүй	үгүй	үгүй		
5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	Тийм	Тийм	Тийм		
6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй		
7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ		Тийм	Тийм		

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Мажрай*...../

огноо

/ 2024 он ..10.. сар ..22.. өдөр /



Найм. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний хяналтын хуудас

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж(удаа)	Г. Төсөв(төг)
1. Хөрс	1	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 1 удаа	2	480.000
2. Ус	2	Уурхайн унд-ахуйн усны зориулалттай гүний худаг Үйлдвэрийн ус цуглуулах эргэлтийн усан сан	2	400.000
3. Амьтан	1	Дуу шуугиан, чичиргээ	-	240.000
4. Ургамал	1	Агаарын тоосны TSP, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub>	-	320.000
5. Агаар	2	ШТМ-ын агуулах Карьерийн дэргэд Гадаад тээврийн замын дэргэд	2	960.000

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Намсрай*...../

огноо

/ 2024 он ...10... сар ...28... өдөр /

**ГАРЧИГ**

1. ОРШИЛ .....	2
2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	3
3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН .....	4
4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	10
5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	11
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
10. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	17
11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	17
12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ .....	18
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	20
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	23
15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	24
16. БОМТ-НИЙ ЗАРДЛЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ .....	25

### **1. ОРШИЛ**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/619 тоот тушаалаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журмын дагуу боловсруулаа. Төв аймгийн Заамар сумын нутаг орших Ар наймганы дээд хэсэг нэртэй алтны шороон ордыг 2024 онд олборлох явцад гүйцэтгэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ордын ашиглах ТЭЗҮ, БОННҮ, 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулав.

Ар наймганы дээд хэсэг нэртэй алтны шороон ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг тогтоож, технологийн шийдлийг зөв сонгон хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй дагаж мөрдөх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргийг уурхай ашиглах техник-эдийн засгийн үндэслэл дээр үндэслэн холбогдох хууль эрхийн бичиг, норм дүрэм, стандарт, заавар журам зэргийн дагуу боловсруулсан.

Уг алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн тодотголыг “Эко хайрхан консалтинг” ХХК 2024 онд хийж батлуулсан.

## **2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Төслийн нэр: “Ар наймганы дээд хэсэг” нэртэй алтны шороон орд  
Төслийн ангилал: “Байгаль орчны үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн хавсралтын дагуу “Уул уурхайн төсөл” ангилалд хамаарна.  
Төслийн дугаар: MV-015478, MV-015480  
Талбайн хэмжээ: 71 га, 15 га  
Төсөл хэрэгжүүлэгч: “Редвулкан” ХХК  
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, нарны зам, 143, 5 тоот Утас: 99071229

Төслийн байршил: Төсөл хэрэгжүүлэх талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах “Ар наймганы дээд хэсэг” нэртэй газарт оршино. Төслийн талбай Заамар сумаас 30 км, “Шижир алт” ХХК, “Алтандорнод Монгол” ХХК-ий уурхайн суурин бүхий Өгөөмөр багийн төв, Хайлаастын тосгоноос 13 км, Улаанбаатар хотоос 249 км-т байрлана.

Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Ар наймганы доод хэсэг нэртэй газарт орших MV-01579 тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг Монгол Улсад бүртгэлтэй “Аварга тосон хэнтий” ХХК-д АМГТХЭГ-ын даргын 2010 оны 02-р сарын 12-ны өдрийн шийдвэрээр олгосон юм. 2012 онд “Редвулкан” ХХК-д шилжүүлсэн байна. Орд газрын ашиглалтын явцад түүх, соёл, археологи, палеонтологийн олдвор илрэх аваас тухай бүрд мэргэжлийн байгууллагад мэдэгдэнэ.

### **Уулын ажлын төлөвлөгөө**

Уурхайн ажиллах горимыг 2024 онд явагдах уулын ажлын хэмжээ, ордын ашиглалтын нөхцөл зэргээс хамаарч 3 сар буюу 75 хоногийн хугацаанд ажиллан гэж төлөвлөлөө. МУ-015478, МУ-015480 тоот ашиглалтын лиценз дэх дээд давхаргын 7-В, 8-В, 9-В, 10-В, 11-В, блокийг бүхэлд нь олборлохоор төлөвлөсөн бөгөөд эдгээр блокоос 175.24 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 74.578 мян.м<sup>3</sup> элс олборлог баяжуулан 16.39 кг алт гарган борлуулахаар байна. 4.6 га талбайн эвдрэлд орох бөгөөд 9200 м<sup>3</sup> шимт хөрс хуулж шимт хөрсний овоолгод хадгалана.

### **3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Тусгай зөвшөөрлийн талбай нь Төв аймгийн Заамар нутаг дэвсгэр дээр оршдог. Төв аймгийн нутаг дэвсгэр Монгол улсын төвийн бүсэд байрладаг. Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Булган, Өвөрхангай зэрэг аймгуудтай хил залгаа оршино. Нийт 74.8 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Дэлхийн цагийн 7 дугаар бүсэд байрладаг. Нутгийн ихэнхи хэсэг нь далайн түвшнээс дээш 1000-1300 м, зүүн хойд хэсэг нь 1500-2500 м өндөрт өргөгдсөн. Хэнтий нурууны ноён оргил 2800 м өндөр Асралт хайрхан энэ бүс нутагт багтдаг. Үүнээс гадна Тосон заамар, Зоргол хайрхан зэрэг уул нурууд бий (Цэгмид, 1979).

Төв аймгийн нутагт уул нуруу, хээр тал, хонхор хөндий зэргийг багтаасан газрын гадаргын хэв шинж олон янз учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь хэд хэдэн бүс муж болон хуваагдах онцлогтой. Нийтэд нь 4 мужид хуваана. Үүнд:

- 1) Чийглэг хүйтэн,
- 2) Чийглэгдүү хүйтэвтэр
- 3) Хуурайдуу хүйтэвтэр
- 4) Хуурай дулаавтар гэж ангилдаг

Заамар сум орчмын уур амьсгал бүрэлдэн тогтох гол онцлог нь хойд талаараа зүүн хойноос баруун урагш чиглэсэн Их Захцагийн уул, Туул голын урд талаар Заамар болон бусад уул нуруудаар алсуур хүрээлэгдсэн 2 талаараа дэнж хэрчигдмэл бүхий төдийлөн гүн биш ам жалганууд нь эндхийн ерөнхий болон бичил уур амьсгал бүрэлдэх дэвсгэр гадаргын нэгэн зүй тогтол болж байна.

Заамар орчмын макро уур амьсгал нь эх газрын эрс тэс, хахир ширүүн, хуурайдуу хүйтэвтэр жилийн 4 улирлын хэв шинжтэй юм.

Өвлийн улирал 11 дүгээр сарын 6-наас дараа оны 3 дугаар сарын 22 хүртэл 136 хоног үргэлжилнэ. Энэ нь манай орны дундаж хугацаатай ойролцоо байгаа юм. Өвлийн онцлог нь цаг агаар тогтуун, нарны өндөр хамгийн бага 17-23° болж, цасан бүрхүүл тогтож, хүйтэн туйлдаа хүрдэг. Хаврын улирал 3 сарын 22-оос 5 дугаар сарын 14 хүртэл 53 хоног үргэлжилдэг. Хаврын онцлог нь өвлийн цаг агаарын эсрэг циклонлог тогтоц задарч, цаг агаарын шинж чанар хувирамтгай болдог. Температур хэдийгээр нэмэгдэх боловч хахиршил ихэсч, жаварлаг болдог. Зуны улирал 5 дугаар сарын 14-нөөс 9 дүгээр сарын 13 хүртэл 122 хоног үргэлжилдэг.

#### **Агаарын температур**

Заамар сумын нутгийн агаарын дундаж, их, бага температурын сар, жилийн явцыг дор харуулав. Агаарын дундаж температур 2020 оны байдлаар 1-12-р сард -24.1 градусаас +18.9 градусын хооронд хэлбэлзэж, 4-10-р саруудад +2.1- +18.9 градус дулаан байхад, 11-3-р саруудад -6.9- -24.1 градус хүйтэн байгаа ба 7-р сард хамгийн дулаан буюу +18.9 градус, 1-р сард хамгийн хүйтэн буюу -24.1 градус хүйтэн байна. Эндээс 6,7,8-р саруудад харьцангуй дулаан, 12,1,2-р саруудад харьцангуй хүйтэн байдаг нь харагдаж байна /Зураг 11.5/. Агаарын температурын жилийн норм энэ бүс нутагт -0.358 градус юм.

Заамар сум орчмын агаарын үнэмлэхүй их, бага температурын жилийн явцыг 7 дугаар зурагт харуулав. 2020 онд Заамар сумын нутагт үнэмлэхүй их температур нь дулааны улиралд +31.9, хүйтний улиралд -8.4 бол үнэмлэхүй бага температур дулааны улиралд +3.6, хүйтний улиралд -36.6 байна.

Агаарын температурын олон жилийн дундаж буюу нормыг Заамар сумын газар нутгаар Заамар болон бусад сумуудын агаарын температурын утгыг ашиглан интерполяци хийх аргаар гаргав. Нутгийн урд хэсгээр агаарын температурын жилийн дундаж утга харьцангуй өндөр, харин сумын төв орчим болон нутгийн зүүн, зүүн хойд хэсгээр харьцангуй бага байдаг нь ажиглагдаж байна.




График 1. Заамар сумын агаарын дундаж температур /2020 он/




График 2. Заамар сумын агаарын температурын норм ба 2020 оны жилийн явц




График 3. Заамар сумын агаарын үнэмлэхүй температур /2020 он/

Заамар сумын орчимд газрын гадаргын халалт, хөрөлт ойролцоо сум буюу Лүнтэй харьцуулахад харьцангуй бага байдаг. Хүйтний улиралд хөрсний гадаргын температур дунджаар -20 градус хүрдэг бол дулааны улиралд +23 градус болдог. Дулааны улиралд хөрсний гадаргын үнэмлэхүй их температур +61 градус, хүйтний улиралд +2 бол, үнэмлэхүй бага температур дулааны улиралд -21, хүйтний улиралд -39 градус болон буурдаг байна



*График 4. Заамар сумын нутаг дэвсгэрийн хөрсний гадаргын дундаж, үнэмлэхүй их болон бага температур*

Заамар сумын нутагт жилд унах нийлбэр хур тунадас 2020 оны байдлаар 328.2 мм байв.



*График 5. Заамар сумын хур тунадасны нийлбэр /2020 он/*

Хур тунадас дулааны улиралд буюу 4-10 дугаар сард хамгийн их орох бөгөөд 7 дугаар сард жилийн нийлбэр хур тунадасны 40 орчим хувь ордог. Хур тунадасны дулаан болон хүйтний улирлын хуваарилагдалтыг авч үзэхэд хүйтний улиралд 6%, дулааны улиралд 94% ордог байна.

2020 оны хур тунадасны жилийн явцыг нормтой харьцуулан 12 дугаар зурагт харуулав. Эндээс үзэхэд Заамар сумын нутгаар хүйтний улиралд орсон хур тунадасны үзүүлэлт олон жилийн дундаж буюу нормтой тохирч байхад 2020 оны дулааны улирлын 6-8 дугаар сард орсон хур тунадасны үзүүлэлт эрс өссөн нь тухайн онд хур тунадас бусад жилүүдээс нилээд ахиу орсныг илтгэж байна.




График 6. Хур тунадасны улирлын хуваарилагдалт

Монгол орны нутаг дэвсгэрт жилийн хур тунадасны ихэнх нь зуны улиралд унах бөгөөд энэ зүй тогтол Заамар сумын тунадасны хувьд ч адил. Зуны саруудад дунджаар 35-60 мм тунадас унадаг бол, өвлийн саруудад харьцангуй бага тунадас унадаг. Мөн ойролцоо сумдын аадар болон зүс бороотой өдрийн тооны харьцааг үзэхэд сүүлийн жилүүдэд зүс бороотой өдрийн тоо нь багасаж, богино хугацаанд усархаг аадар тунадас ажиглагдах нь ихсэх төлөвтэй байгаа юм.

### Салхи шуурга

Уул уурхайн үйлдвэрлэлд тухайн бичил орчны ба нутаг дэвсгэрийн салхины ерөнхий горим ихээхэн нөлөөтэй байдаг. Салхины ноёлох чиглэлийн давтагдал, хурд, цасан болон шороон шуурга, хүчтэй салхи, салхины ачаалал нь технологийн хэм хэмжээг тодорхойлох, байгаль орчинд тоос шороо тархах гол хүчин зүйл болдог. Заамар сумын салхины дундаж хурд нь 3.4-5.5 м/с бөгөөд хавар, намрын саруудад ихэвчлэн баруунаас зүүн хойш чиглэдэг. Бусад чиглэлд жилд дунджаар 1.3-3.7 м/с хурдтай салхилдаг. Салхины жилийн дундаж хурд нь 2.9 м/с.



График 7. Салхины дундаж хурдны жилийн явц /2020он/



Заамар сумын нутаг орчмын салхины хамгийн их хурдыг 14 дүгээр зурагт харуулав. Эндээс үзэхэд 2020 оны байдлаар салхины хамгийн их хурд намрын улиралд буюу 10, 11 дүгээр саруудад ажиглагдаж байгаа бол 1, 2, 7, 8 дугаар саруудад салхины их хурд харьцангуй бага, харин 3-6, 9 ба 12 дугаар сард нутгийн хэмжээнд 9 м/с хүрч салхилдаг байна.

### **Нарны цацраг**

Нарны цацрагийн нөлөө үйлчлэлээр газрын гадарга халж, хөрж агаар орчны дулаан хүйтний нөөц горимыг бий болгодог.

Жилдээ 2750-2850 цаг нар гийгүүлэх бөгөөд өвлийн саруудад 155-210 цаг, зуны саруудад 290-330 цаг, хавар, намрын саруудад өсөлт бууралтын явц ойролцоо байдаг. Өвлийн нэг өдөрт 5.6-6.5 цаг, зуны нэг өдөрт 9.5-10.5 цаг нар гийгүүлдэг.


### **Ус зүй**

Монгол орны ай савын ангиллаар Хойд Мөсөн Далайн ай савд багтдаг. Төв аймгийн нутаг дэвсгэрээр урсан өнгөрөх голууд нь гол мөрний горимын ангиллаар хаврын шар усны ба дулааны улирлын хур борооны үертэй голуудад хамаардаг.

Ашиглалтын талбай нь Туул голын ай савд байрлана. Туул гол Хан Хэнтий нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах, Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Сарьдагийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол, горхи Туул голд цутгадаг. Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавиурч урсацын алдагдал ихэснэ. Туул гол үерлэхдээ сав хөндийгөө дүүргэж, хуучин гулдиралдаа эргэн орж, үндсэн гулдирлаас алслан салаалдаг. Туул голын өргөн нь жирийн үед 35-37 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0.50-1.50 м/с болно. Голын ус хурах талбай 49840 ам км, урт нь 704 км /Мягмаржав ба Даваа, 1999/.

### **Хөрс**

Төв аймгийн Заамар сум орчмын хөрс бүхэлдээ уулын хүрэн шороон хөрсний ангилалд хамаарна. Хүрэн хөрсний хэв шинж А-Вm-Вса(В)-ВСса(ВС)-Сса(С) гэсэн үндсэн үе давхаргатай. Ялзмаг хуримтлалын (А) давхарга нь хархүрэн, хүрэн, хүрэвтэр бор, сааралдуу борхүрэн, цайвар хүрэн өнгөтэй, бөөмөрхөг бүтэц сул илэрсэн, гадаргаасаа эхлээд сайр чулуутай, доод хил зааг нь тод, зузаанаараа 5-10 см-ээс 20-25 см хүртэл янз бүр. Ялзмагийн агууламж багатай, ихэнх тохиолдолд бүдэг илэрсэн метаморф шинжтэй Вm давхарга нь хүрэвтэр бор, бор, цайвар бор өнгөтэй, нягтавттар, сайр чулуу ихтэй (эзлэхүүний 60-80% хүртэл), зузаан нь 8-10 см-ээс 20-25 см хүрнэ. Карбонатын хуримтлалын Вса, ВСса давхаргууд нь нунтаг карбонатын нэвчмэл цайвар толбууд бүхий бор шар, шар өнгөтэй, заримдаа карбонатын хуримтлал нь морфологийн хувьд тод илэрч харагдахгүй, сайр чулуу ихтэй (эзлэхүүний 70-90% хүртэл), нунтаг шороо нь чулуунуудын зай завсраар чигжиж тогтсон байна. Вса давхаргын зузаан 15-20 см, ВСса давхаргынх 20-25 см орчим байна. Сумын хэмжээнд хөрсний чанарын үзүүлэлт 60-80 баллтай, хөрсний доройтол нь уурхайн нөлөөгөөр 30-50 км<sup>2</sup> эвдэгдсэн гэсэн ангилалд тус тус багтаж байна /Монгол улсын үндэсний атлас, 2009/.



Зураг 1. Заамар сумын нутаг дах хөрс, ургамлын ангилал

### Ургамлын аймаг

Төв аймгийн Заамар сумын бүс нутаг Монгол орны ургамлын 16 тойргийн ангиллаар бүхэлдээ Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт багтдаг. Ургамлын байгалийн бүс бүслүүрийн ангиллын хувьд Заамар сумын нутаг нь цэлийн хээр, өндөр уулын, уулын ойт хээр, уулын хээр, бэлчээрийн бүс, хээр ба хуурай хээр гэсэн ангилалд хамаарна. Судалгааны талбайн орчимд бэлчээрийн бүс, хээр ба хуурай хээр, уулын хээрт зонхилох ургамлууд голлон ургасан байна. Ургамлын хэв шинж нь уул хоорондын хөндий, бэлийн хялганат хээрийн төрхтэй юм. Уулын энгэрт удвал навчит тавилгана зэрэг сөөглөг ургамал, мөн гишүүнэ, туйпланцар багваахай зэрэг нилээд тохиолдоно.

### Амьтны аймаг

#### Хөхтөн:

Заамар сум орчимд 36 зүйлийн махчин, туруутан, мэрэгч тэн зэрэг хөхтөн амьтан тархсан байна. Эндээс бүс нутгийн хэмжээнд 24 зүйл анхааралд өртхөөргүй, 5 зүйл мэдээлэл дутмаг, 2 зүйл устаж болзошгүй, 5 зүйл ховордож болзошгүй гэсэн ангилалд багтаж байна. Харин олон улсын үнэлгээгээр 33 зүйл анхааралд өртхөөргүй, 2 зүйл ховордож болзошгүй, 1 зүйл эмзэг гэсэн статустай байгаа юм.

#### Шувуу:

Заамар сумын орчимд, Туул голын сав газарт 102 зүйл шувуу тэмдэглэгдсэн байна. Энэ бүс нутагт тохиолдох шувуудын бүс нутгийн статусыг авч үзвэл ховордож болзошгүй 3 зүйл, эмзэг 5 зүйл, устаж болзошгүй 2, устаж байгаа 1 зүйл, харин олон улсын үнэлгээгээр ховордож болзошгүй 5 зүйл, эмзэг 3 зүйл, устаж болзошгүй 2, устаж байгаа 1 зүйл тус тус байна.

**Хоёр нутагтан, мөлхөгч:**

Тус сумын орчимд 5 зүйл хоёр нутагтан, мөлхөгч тархсан бөгөөд эдгээр нь түгээмэл тохиолддог зүйлүүд учир бүс нутгийн болон олон улсын хамгааллын статуст анхааралд өртхөөргүй, үнэлгээ хийгдээгүй гэсэн ангилалд багтдаг.

Монгол орны гол, мөрөн, нууруудад нийт 74 зүйл загас тархсан. Монгол улсын загасны улаан дансанд тэмдэглэснээр Туул голын сав газарт 8 зүйл загас бий.

**Хүн ам дэд бүтэц**

Төслийн талбай нь Заамарын алтны зангилаа бүсийн төвд байрладаг учраас цахилгаан хангамж, авто замын сүлжээ, усан хангамж, түлш, модон материалаар уурхайг хангахад эдийн засгийн хувьд үр ашигтай болох нь тодорхой юм. Тус суманд 12 жилийн сургууль, 10 жилийн сургууль болон хоёр цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, бүс дундын цагдаагийн газар, хоёр хүн эмнэлэг болон бусад үйлдвэр үйлчилгээний газрууд үйл ажиллагаагаа явуулж байна.

**4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ  
ТОДОРХОЙЛТ**

**Голлох нөлөөллийн үнэлгээ**

Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Харин төслийн үйл ажиллагааны үр дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна.

*Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл*

Овоолгын талбайгаас салхинд хийсэх тоосны хэмжээ:

Шинээр хөрс буулгасан хэсэгт – 0.54 мг/м<sup>2</sup>с

Хөрс буулгаснаас хойш 3 сарын дараа – 0.32 мг/м<sup>2</sup>с

Ил уурхайн аргаар эрдэс түүхий эд олборлоход их хэмжээний хөрс хуулалт хийх, карьер, овоолго бий болох зэргээр уул уурхайн орчин нь үндсэндээ тоос тархах эх үүсвэр болдог. Иймд уурхайн ашиглалтын хэсэгт хамаарах газрыг бүхэлд нь тоос тархах задгай талбай гэж үзэж болох юм.

***Гадаргын болон гидрогеологи.***

Ар наймганы хэмжээнд усны байгалийн нөөц 1448-1933 шоо метр хоног байна. Дөрөвдөгчийн аллювийн хурдсан дахь гүний ус нь цэнгэг, эрдэсжилт 0.4 г/л-ээс илүүгүй. РН-ийн хэмжээ 7.5-8.4. Ерөнхий хатуулаг 4.3 мг-экв-ээс илүүгүй. Газрын доорхи ус нь найрлагаараа ундны усны шаардлагыг бүрэн хангана. Туул голын газрын доорхи ус нүүрс хүчлийн хий болон хүчил, сульфат, магнийн зэрэг идэмхий агуулагчгүй юм. Иймд Ар наймганы доод хэсэг орд нь гидрогеологийн энгийн нөхцөлтэй.

## **5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад, мөн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийж гүйцэтгэх нь тус байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго оршино.

Үүнд:

- Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрт эрт илрүүлэх
- Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийж гүйцэтгэнэ.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Редвулкан” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

**6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар орчин	Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ, CO, SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> ихсэж, орчны хүчилтөрөгчийн (O <sub>2</sub> ) хэмжээ багасах.	Ашиглаж буй бүх техник хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд оруулж байх	Төсөлд ашиглагдах бүх авто машин	-	-	10	-	Төслийн бүх үе шатанд 2024 он	Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
3	Усны нөөц, чанар	Газрын доорх усыг авч ашигласанаар газрын доорх урсцын горим алдагдах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох	Амторын септик танкнаас гарч буй усанд шинжилгээ хийлгэж MNS 4943:2015 стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлох (хяналтын цооноогоос дээж авч шинжилгээ хийлгэх).	1			1		2024 он	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586-98 (СХЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол), Усан орчны чанарын хяналт шинжилгээ MNS4047-88 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал), Усны чанар, хаягдал бохир ус. MNS 4943-2014
			Ундны усны савыг 7 хоног бүр ариутгаж, цэвэрлэж байх	Ундны усны сав			1	-	2024 он	

4	Хөрсөн бүрхэвч	Ургамал нөмрөг хүн, мал, техникийн нөлөөгөөр устгах, сийрэгжих, улмаар энэ нь ургамал нөмрөг их хэмжээгээр эвдрэлд орно.	Хоол хүнсний органик хаягдлыг бордоо болгох	Хоол хүнсний хаягдал	2.5		2.5	2024	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5916:2008 MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
			Олон салаа зам гаргахгүй нэгдсэн маршрутаар зорчиж байх, хурдны хязгаар тогтоох	Гадаад болон дотоод тээврийн зам				2024 он	
			Шатах тослох материал, хог хаягдал түр хадгалах цэг, засварын газрын доорх талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Хогийн цэг, шатах тослох материал түр хадгалах цэг засварын газар	0.6		0.6	2024 он	

5	Ургамал , амьтны аймаг	Хөхтөн, шувууд зэрэг амьтдыг дуу чимээ, гэрэл, машин техникийн ажиллагаа зэрэг газар шорооны үйл ажиллагааны улмаас үргээж, дүрвэх ба айлган цочоож болзошгүй.	Зэрлэг амьтдын амьдардаг гол тархацнутаг, уст цэг орчимд өвс, тэжээл, хужир шүү, давс тавьж өгөх, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээ авах	Төслийн талбай	2.0		2.0	Төсөл хэрэгжих үед байнга	
		Нөлөөллийг бууруулах нийт зардал						5.1 сая	

**7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмж их нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэм жээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгж үүлэх хугацаа давтам ж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
<b>Техникийн нөхөн сэргээлт</b>								
1	Эвдрэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	2024 онд уул техникийн нөхцөлөөс хамаарч техникийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй	га	-	-	--		”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/
<b>Биологийн нөхөн сэргээлт</b>								
2	Уурхайн ашиглалтын талбайд эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээх	2024 онд уул техникийн нөхцөлөөс хамаарч биологийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй	га	-	-	-	-	”Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2008/
	<b>Нийт</b>							



**8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн үнэлгэе, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	456	7	8	
1	Дүйцүүлэн хамгааллын ажил хийх талбайг орон нутгийн удирдлагатай тохиролцон сонгох	Орон нутгийн удирдлагаас санал авах	Ашиглалтын 2 дахь жилээс Дүйцүүлэн хамгааллын ажил хийгдэнэ. Орон нутгаас санал авна.	- ҮАЗ		2025 он	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
<b>Нийт</b>				-			

**9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Соёлын дурсгалт зүйлсийг авран хамгаалах ажлыг хийсэн болно .МУ-ын ШУА-Палеонтологийн төв, Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг “Редвулкан” ХХК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр 168.0 га талбайд МУ-ын ШУА-Палеонтологийн судалгааны төвийн судлаачид 2013 онд палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5-р бүлгийн 27-р зүйлийн 8-д заасны дагуу 168 га хайгуулын талбайд ШУТИС-Бизнесийн удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын археологи-угсаатны зүйн багийн нэр бүхий судлаачид 2019 оны 9-р сарын 09-ээс 9-р сарын 15-ны өдөр авран хамгаалах хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэсэн.

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал (сая.төг)		Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Археологийн дурсгал	Олборлолтын үйл ажиллагаанд түүх соёлын өвүүд илэрвэл	Үйл ажиллагаа явуулах явцад хөрсөн доороос археологи, палентологийн дурсгал илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад даруй мэдэгдэнэ.	-	-	-	2024 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Палеонтологийн дурсгал	Олборлолтын үйл ажиллагаанд олдвор илэрвэл	Ордын хэмжээнд палеонтологийн дурсгал илрээгүй болно	-	-	-	2024 он	
<b>Нийт</b>					<b>ҮАЗ</b>			

